



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/38

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний яамнаас эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, дэд станц, ухаалаг тоолуур суурилуулах (Ховд Жаргалант сум)-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ш.Нохойжав	- Орон нутгийн өмчийн газрын дарга
Гишүүдэд:	Б.Далайбаяр	- Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
	Г.Ууганчимэг	- Төрийн бус байгууллагын төлөөлөл
	М.Адуучин	- Иргэний төлөөлөл
Нарийн бичиг:	Х.Дэмид	- Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Ш.Нохойжав)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Х.Дэмид)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

8400 03 0193

D/Tush-A/38-Bo